



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
III. ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 05/03


Булган

Концессын зүйлийн жагсаалт
батлах тухай

Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3, Концессын тухай хуулийн 4.1.3, 4.1.6, 6.1.2, 6.2.3, 10.2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн 3-р хуралдаанаас ТОГТООХ НЬ


1. Орон нутгийн өмчийн Концессын зүйлийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Жагсаалтанд тусгагдсан ажлуудад хөрөнгө оруулалтыг татан оруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан үр дүнг тооцон Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн ажлын хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгуулж гэрээг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга /Д.Эрдэнэбат/ -д даалгасугай.
3. Жагсаалтад тусгагдсан төсөл арга хэмжээний концессын гэрээг тухай бүр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, зөвшөөрлүүлэх, биелэлтийн явц, хүрсэн үр дүн хэрэгжилтийн талаар улирал тутам танилцуулахыг Засаг дарга / Д.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА,



М.ОЮУНБАТ

Булган аймгийн ИТХ-ын 2013 оны 11 удаагийн
сонгуулийн III хуралдааны 25-р тогтоолын хавсралт



КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

№	Концессын зүйлийн нэр	Концессийн зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх
Үйлдвэр, үйлчилгээний салбарт						
1.	Шахмал түлш, зүймэл хавтангийн үйлдвэр	Хялганат тосгонд барих	Барих-өмчлөх-ашиглах	Дэвшилтэт технологи бүхий шахмал түлш болон зүймэл хавтангийн үйлдвэр байгуулах	Орон нутгийн хөгжлийн сангаас дэмжлэг үзүүлнэ. / 2013 онд 244,463.0 мянган төгрөг туссан байгаа/	Гэрээ байгуулах
2	Сумдад ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүд барих	Сумдад ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүдийг байгуулж, Булган суманд хуучин барилга ашиглаж, буулгаж шинээр барих	Барих-өмчлөх-ашиглах	Сумдад ахуйн үйлчилгээний цогцолбор барьж байгуулна.	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
3	Жилийн 4 улиралд ажилладаг хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах	Булган, Бугат, Хялганат, Орхон сумдад 6 x 20 = 120 м ² хэмжээтэй хүлэмжийн аж ахуй байгуулна.	Барих- өмчлөх-ашиглах	Элэгдэлд орсон газрыг бордож ашиглах	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
4	Чулуу бутлан ангилах үйлдвэр байгуулах	Чулуу бутлан ангилах үйлдвэр байгуулах	Барих-өмчлөх-ашиглах	Барилгын материалын үйлдвэр ашиглалтад	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах

	байгуулах			барьж байгуулах		
6.	Бетон зуурмагын үйлдвэр байгуулах	Булган аймгийн төвд цагт 30 м ³ хүчин чадалтай бетон зуурмагын үйлдвэр байгуулах	Барих- өмчлөх-ашиглах	Бетон зуурмагын үйлдвэр байгуулах	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
7.	Шохой боловсруулах үйлдвэр байгуулах	Шохой боловсруулах үйлдвэр байгуулах	Барих-өмчлөх-ашиглах	Шохой боловсруулах үйлдвэр барьж байгуулах	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
8.	Аймгийн төвд дулаан тусгаарлах, хөнгөн дүүргэгч, хөнгөн бетоны үйлдвэр байгуулах	Аймгийн төвд дулаан тусгаарлах, хөнгөн дүүргэгч, хөнгөн бетон	Барих-өмчлөх-ашиглах	Барилгын материалын хөнгөн дүүргэгч, хөнгөн бетоны үйлдвэр барьж ашиглалтад оруулах	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
9.	Эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэл байгуулах	Эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийг байгуулна.	Барих-өмчлөх-ашиглах	Барилгын материалын эрдэс хөвөн хонины ноосон дулаалгын материалын үйлдвэр байгуулна.	Төсвийн хөрөнгө шаардлагагүй	Гэрээ байгуулах
Дэд бүтцийн салбарт						
10.	Нэгдсэн халаалтад шилжүүлэх	Могод сумын сургуулийн нэгдсэн халаалтын зуух, тоног төхөөрөмж, дулааны шугам сүлжээг шинэчилж, бусад төсөвт байгууллагуудыг холбох	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Халаалтын зуух, тоног төхөөрөмжийг шинэчлэн, дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, шаардлагатай зам талбайг барих санхүүжүүлэх, дулаан үйлдвэрлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
11.	Нэгдсэн халаалтад	Орхон суманд нэгдсэн халаалтын систем барьж албан	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Халаалтын зуухны барилга байгууламж барих, инженерийн дэд бүтэц, шаардлагатай зам	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах

				шилжүүлэх		
12.	Булган хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр төлөвлөж, сэргээн засварлаж сайжруулах	Булган хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр төлөвлөж, сэргээн засварлаж сайжруулах замаар байгаль орчин, хөрс усны бохирдлыг багасгах	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Булган хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчилж, байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
13.	Булган хотын дулааны шугам сүлжээг өргөтгөх	Булган хотын гэр хороолол руу дулааны шугам сүлжээ барих	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Булган хотын дулааны шугам сүлжээг өргөтгөх зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
14.	Тэшиг сумыг 35 кВт-ын өндөр хүчдэлийн шугамд холбох.	Цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
15.	Цахилгаан эрчим хүчинд холбох	Хутаг-Өндөр сумын Тээл, Тэшиг сумын Хужирт, Орхон сумын Халиун баг руу дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамын хамт барих	Зураг төсөв боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
	Нийт -15 ажил					